



“ХОББИ” СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН ДҮРЭМ

1. “Хобби” сургуулийн суралцагчийн **ЭРХЭМ ЗОРИЛГО** нь өөрийн биеийг дайчлан эрдэмд шамдан суралцаж, ихийг олж мэдэхийн зэрэгцээ хүнлэг, сайхан сэтгэлтэй, оюунлаг, урлаг ойлгож биширдэг, бүтээлч, эх оронч сэхээтэн болж, Монгол Улс болон сургуулийнхаа нэр хүндийг ямагт өндөрт авч явахад оршино.
2. Суралцагч бүр өөрийн үндсэн үүрэг болох сурах, суралцах үйлсэд хичээнгүйлэн зүтгэнэ:
 - 2.1 Сургуульдаа ирэхдээ хичээлийн бэлтгэлийг бүрэн хангасан байна.
 - 2.2 Хичээл эхлэхээс 10-15 минутын өмнө ирж суудлаа эзэлсэн байна. Хоцорсон тохиолдолд хичээлийн дундуур анги танхимд оролгүй дараа цагийн хичээлд орж сууна.
 - 2.3 Хичээлээ анхааралтай сонсож, ойлгоогүй зүйлийг багшаасаа асууж, шаардлагатай бол давтлага авч, сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмшихийг эрмэлзэнэ.
 - 2.4 Багшийн тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлнэ.
 - 2.5 Багшийн өгсөн гэрийн даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ.
 - 2.6 Хичээлийн эцэст “Суралцагчийн харилцах дэвтэр”-т гэрийн даалгавар болон шаардлагатай мэдээллийг тэмдэглэн долоо хоног бүрийн эцэст эцэг эхийн аль нэгээр гарын үсэг зуруулж байна.
 - 2.7 Мэдлэгийнхээ хүрээ, авьяас чадвараа бүрэн хөгжүүлэх зорилгоор дугуйлан, секц, сонгоны хичээлд идэвхтэй оролцоно.
 - 2.8 Өвчний болон бусад шалтгаанаар хичээлээс хоцрох, таслах тохиолдолд эцэг эхээсээ тайлбар зурвас буюу эмчийн магадлгааг заавал авчирч багшдаа өгөх ба тухайн цагийн, өдрийн хичээлээ багшаас зөвлөгөө авч нөхөн, шалгуулна.
3. Сурч боловсрохын зэрэгцээ сургуулийнхаа ажил амьдрал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, олон нийт, нийгмийн болон сайн үйлсийн аянд идэвхтэй оролцоно.
4. Соёлч, боловсон байдлыг төлөвшүүлнэ:
 - 4.1 Ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгээ эелдэг, зөв боловсон харьцаж мэндлэх, хүндлэх ёсыг хэвшүүлж сурна;
 - 4.2 Анги танхимаа цэвэр үзэмжтэй байлгаж, тоног төхөөрөмж, эд хогшилд эзний ёсоор хандаж ашиглана;
 - 4.3 Суралцагч нь хичээлийн байранд дараах байдлаар цэвэр цэмцгэр хувцаслаж, биеэ зөв зохистой авч явна. Үүнд:
 - 4.3.1 Даваа-Пүрэв гарагуудад сургуулийн дүрэмт хувцсыг иж бүрдлээр нь цэвэр нямбай өмсөнө. */Дүрэмт хувцасны банзлыг өвдөгнөөс дээш 3 хуруугаас илүүгүй байхаар тааруулах/*
 - 4.3.2 Чөлөөт хувцаслах өдөр буюу Баасан гараг дор дурдсан хувцсыг өмсөхгүй.
 - Хэт богино даашинз, банзал, шорт;
 - Зохисгүй үг хэллэг болон зурагтай хувцас;
 - Нуруу, гэдэс, суга ил гарсан, цээж хэт ил гарсан, цамц, майк, даашинз;
 - Дугуйтай пүүз;
 - Өндөр өсгийтэй гутал;
 - Хэт том, гялгар эзэмэг, зүүлт, бугуйвч, хэрэгсэл;
 - 4.3.3 Охидууд нүүр болон хумсаа тод өнгөөр будахгүй байна.

5. Сургуулийн анги танхим, орчинд доорх үйлдлийг хориглоно:
 - 5.1 Хичээлийн явцад буюу аливаа шалгалт шүүлэг өгч буй үед багш болон суралцагчдад ноцтой саад учруулах /Багшийн зөвшөөрөлгүй орж гарах, хуулж бичих, багшийн тавьсан шаардлагыг үл тоомсорлох/;
 - 5.2 Хичээлийн цагаар гар утас, iPad гэх мэт зүйлс хэрэглэх;
 - 5.3 Анги танхимдаа хүнсний зүйл авч орох;
 - 5.4 Их хэмжээний мөнгө, үнэтэй эд зүйлс авч ирэх /Авч ирсэн тохиолдолд өөрсдөө хариуцлага хүлээнэ./;
 - 5.5 Хөзөр, мөрийтэй тоглоом тоглох;
 - 5.6 Элдэв этгээд, бүдүүлэг, хараалын үг хэлэх;
 - 5.7 Хог хаях;
 - 5.8 Бохь зажлах;
 - 5.9 Исгэрч шүгэлдэх;
 - 5.10 "Суралцагчийн хувцаслалтын журам"-ыг зөрчих;
 - 5.11 Бусдад муу үлгэр дуурайл үзүүлэх аливаа үйлдэл хийх.
6. Суралцагч дараах ноцтой үйлдэл гаргахыг хатуу хориглоно.
 - 6.1 Тамхи татах, согтууруулах ундаа болон мансууруулах төрлийн зүйл хэрэглэх;
 - 6.2 Зодоон хийж танхайрах, бусдын амь нас, бие, эрүүл мэндэд заналхийлэх буюу хохирол учруулах,
 - 6.3 Зэвсгийн чанартай, хурц, шовх үзүүртэй, иртэй гэх мэт бусдыг гэмтээж болзошгүй эд зүйлс, эм бэлдмэл, химийн бодис авч ирэх;
 - 6.4 Бусдын эд хөрөнгийг гэмтээх, хулгай хийх;
 - 6.5 Багш, сургуулийн ажилтнуудтай зүй бусаар харьцах, хэл амаар доромжлох, гутаах, илтээр үл хүндэтгэсэн байдал гаргах.
7. Энэхүү журмыг дагаж мөрдөөгүй суралцагчдад дараах арга хэмжээг авна.
 - 7.1. Дүрмийн 2-5 дугаар зүйлийг зөрчсөн сурагчдад доорх шат дараалсан арга хэмжээ авна:
 - 7.1.1. 1 удаа зөрчсөн тохиолдолд анги удирдсан болон тухайн хичээлийн багш сануулга өгнө.
 - 7.1.2. 2 удаа зөрчсөн тохиолдолд сургалтын менежер, нийгмийн ажилтан анхааруулга өгнө.
 - 7.1.3. 3 удаа зөрчсөн тохиолдолд сургалт хариуцсан захирал суралцагч болон эцэг эхэд анхааруулга өгч, дахин зөрчил гаргавал хасах хүртэл арга хэмжээ авахыг сануулна.
 - 7.1.4. 4 удаа зөрчсөн тохиолдолд багш нарын хурлаар оруулж цаашид суралцуулах эсэхийг шийдвэрлэнэ.
 - 7.1.5. Багш нарын хурлаар суралцуулах шийдвэр гарч, анхааруулга авсан сурагч дахин зөрчил гаргасан тохиолдолд сургуулиас шууд хасна.
 - 7.2. Дүрмийн 6 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан тохиолдолд гэрээ цуцалж, сургуулиас хасна.
 - 7.3. Анги удирдсан багш суралцагч зөрчил гаргасан тохиолдол бүрийг цаг тухайд нь дүрэмд заасан албан тушаалтнуудад мэдэгдэж зохих арга хэмжээ авахуулах, авсан арга хэмжээний талаар цахим шуудан, "суралцагчийн харилцах дэвтэр"-ээр дамжуулан эцэг эхэд мэдээлнэ. Мөн зөрчил гаргасан суралцагчдын бүртгэл хөтөлнө.
 - 7.4. Холбогдох багш, албан тушаалтан нь "Суралцагчид арга хэмжээ авах хуудас"-нд суралцагч ямар зөрчил гаргасныг дэлгэрэнгүй тэмдэглэж өөрийн болон суралцагчийн /6-12-р ангийн сурагчдад хамаарна/ гарын үсгээр баталгаажуулан хувийн хэрэгт нь хавсаргана.